


ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ТАНИЛЦУУЛГА

Өвөрхангай аймгийн Нэгдсэн эмнэлэг анх 1928 онд байгуулагдсан. Монгол Улсын Засгийн Газрын 2001 оны 194-р тогтоолоор аймгийн Нэгдсэн эмнэлгийг Бүсийн оношилгоо эмчилгээний төв болгон өргөтгөсөн. Тус эмнэлэг нь Өвөрхангай аймгийн 116,8 мянган хүн амаас гадна Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай аймгийн 130,0 мянга, нийт 246,8 мянган иргэдэд 3 дахь шатлалын нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг үзүүлэн ажилладаг.

1. БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

БОЭТ нь оношлох, эмчлэх, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил гэсэн 3 үндсэн чиглэлээр; 4 клиник, 11 тасаг, 17 албатай 330 ортой, 470 хүний нөөцтэй үйл ажиллагаагаа явуулдаг. Их эмч 127, үүнээс мэргэжлийн зэрэгтэй 54 буюу 42.4%, үндсэн болон төрөлжсөн мэргэжил эзэмшсэн 124 (98%). Сувилагч тусгай мэргэжилтэн 235, үүнээс мэргэжлийн зэрэгтэй 31.3% (74), төрөлжсөн нарийн мэргэжил эзэмшсэн 68% (160) байна. Бусад ажилтан 108, үүнд үйлчилгээний ажилтан, ХАБ эрсдэлийн менежер, хүний нөөцийн менежер, санхүүгийн ажилтан, тоног төхөөрөмжийн инженер, техникч, аж ахуйн ажилтан зэрэг хамрагдана.



2. ТӨСӨВ, САНҮҮЖИЛТ:

Төсвийн санхүүжилт (мян төг):

Утга	2019	2020	2021	2022 оны эхний хагас жилийн байдлаар	Бүгд
Улсын төсвөөс	4,378,330	6,300,316			10,678,646
ЭМДС-аас	3,710,188	4,346,815	12,236,025	14,731,391	35,024,419
Өөрийн орлого	165,307	194,714	201,020	135,329	693,370
Дүн	8,253,825	10,841,845	12,437,045	14,866,720	46,399,435

Төсвийн гүйцэтгэл (мян төг):

Утга	2019	2020	2021	2022 оны эхний хагас жилийн байдлаар	Бүгд
Цалин, НДШ	5,739,138	7,298,850	8,298,850	4,950,228	26,926,309
Тогтмол зардал	458,046	524,989	622,452	574,947	2,180,433
Хангамж, бараа материал	147,492	172,790	193,128	94,955	608,365
Эд, хогшил урсгал засвар	225,677	784,085	92,480	174,390	1,276,630
Норматив зардал	1,592,444	1,959,175	2,672,685	3,104,893	9,329,196
Бусад	91,030	101,957	47,468	26,768	267,221
Дүн	8.253.825	10.841.845	12.566.304	8.926.181	40.588.155

3. ТЕХНИК ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ:

БОЭТөв нь 14,854,381,233,87 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй.

- Маммографи
- Дижитал рентген
- 4D ЭХО, 3D ЭХО, дуран
- Зүрхний ЭХО
- Ургийн зүрхний хяналтын нэгдсэн монитор
- Нярайн түнхний ЭХО,
- Компьютер томографи
- Ангиографи
- Бусад техник тоног төхөөрөмжөөр хангагдсан.

Амбулаторийн эмчийн үзлэгийн цагийг урьдчилан захиалах үйлчилгээнд “CALL PRO” операторын шинэ технологийг нэвтрүүлэн ажилладаг.

Бөөр шээсний доод замын дурангийн мэс засал, үргүйдэлтэй эмэгтэйчүүдэд дурангийн оношилгоо, өвдөг түнхний үе солих мэс заслын оношилгоо хийж, тусламж үйлчилгээг үзүүлдэг. 24 цагийн интернет орчин бүхий, алсын зайн оношлогооны телемедициний иж бүрэн тоног төхөөрөмж бүхий орчин үеийн оношилгоо эмчилгээний төв, сургалтын бааз болон хөгжсөн.

Улсын төсвийн болон орон нутгийн санхүүжилтээр сүүлийн жилүүдэд Хүчил төрөгчийн үйлдвэр, хүүхдийн 50 ортой эмнэлэг, ариутгал, уламжлалтын эмнэлэг, амбулаторийн засвар үйлчилгээ, Health promotion center / Эрүүл мэндийг дэмжих төв/ байгуулах, Чанарын удирдлагын тогтолцоо ISO -9001:2015 нэврүүлэх зэрэг томоохон хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтууд хийгдсэн.

4. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ:

Тус төв нь жилдээ 110000 гаруй амбулаторийн үзлэг, стационарт 9000-10000 гаруй өвчтөн хэвтүүлэн эмчилдэг.

	2019	2020	2021	2022 эхний хагас жилийн байдлаар
Хэвтэн эмчлүүлсэн хүний тоо	10687	9689	10065	6098
Амбулатороор үйлчлүүлсэн хүний тоо	122078	62723	37962	77510

Ор ашиглалт:

Үзүүлэлт	2019	2020	2021	2022 оны эхний хагас жилийн байдлаар
Ажилласан орны тоо	305	330	330	330
Дундаж ор хоног	6,5	7,09	7,2	7,1
Ор ашиглалтын хувь	63,7	61,1	58,01	73,9

Нас баралт:

	2019	2020	2021	2022 оны эхний хагас жилийн байдлаар
Нас баралтын хувь	0,6	0,4	0,8	0,6
Хоног болоогүй нас баралтын хувь	21,9	28	15,8	21,1

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА.

Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Захирлын албан тушаалын сонгон шалгаруулалтад оролцохыг урьж байна.

Нэг. Тавигдах шаардлага

Сонгон шалгаруулалтад оролцох иргэн дараах шаардлагыг хангасан байна.

- 1/ Эрүүл мэндийн салбарт 10-аас доошгүй жил ажилласан;
- 2/ Эрүүл мэндийн байгууллагад 5-аас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласан;
- 3/ Нийгмийн эрүүл мэндийн болон анагаах ухааны боловсрол олгох их дээд сургууль төгссөн;
- 4/ Баклавар ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй;
- 5/ Эрүүл мэндийн удирдлагаар мэргэшсэн;
- 6/ Тодорхой албан тушаал эрхлэх буюу үйл ажиллагаа явуулах эрх нь шүүхийн шийдвэрээр хасагдаагүй;
- 7/ Улс төрийн намын гишүүн бус;
- 8/ Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад удирдах албан тушаал эрхэлдэггүй;
- 9/ Бусад байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагын бүрэлдэхүүнд хавсран ажилладаггүй;

Хоёр. Сонгон шалгаруулалтад оролцоход бүрдүүлэх материал

Шаардлага хангасан иргэн дор дурдсан материалыг бүрдүүлж өгнө.

- 1/ Төрийн албан хаагчийн анкет (Төрийн албаны зөвлөлөөс баталсан маягтын дагуу);
- 2/ Иргэний үнэмлэхийн эх хувь эсхүл Улсын бүртгэлийн лавлагаа;
- 3/ Тухайн албан тушаалд томилогдох хүсэлт, бүрдүүлсэн материалын баталгааг илэрхийлсэн өргөдөл;
- 4/ Мэргэжлийн мэдлэг, ур чадварын чадавхыг илэрхийлсэн хоёр хүний тодорхойлолт (өмнө нь ажиллаж байсан эсхүл одоо харьяалж буй байгууллагын дарга/, захирал тухай иргэний гишүүнчлэлтэй мэргэжлийн нийгэмлэг, холбооны удирдах зөвлөл эсхүл гүйцэтгэх захирлын);
- 5/ 4x3 см хэмжээтэй 2 хувь цээж зураг;
- 6/ Нийгмийн эрүүл мэндийн болон анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль төгссөн, эрүүл мэндийн удирдлагаар мэргэшсэнийг нотлох баримт бичиг /боловсролын диплом, мэргэшлийн үнэмлэхийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, эх хувийн хамт/;
- 7/ Эрүүл мэндийн салбарт 10-аас доошгүй жил ажилласныг нотлох баримт /хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтрийн холбогдох хэсгийг хуулбарлан эх хувийн хамт/;
- 8/ Эрүүл мэндийн байгууллагад 5-аас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласныг нотлох баримт /хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтрийн холбогдох хэсгийг хуулбарлан эх хувийн хамт/;
- 9/ Англи хэлний мэдлэгийн түвшинг тодорхойлох баримт бичиг ("TOEIC", "TOEFL", "IELTS" олон улсын шалгалтын гэрчилгээний хуулбар, эх хувийн хамт эсвэл олон

улсад хүлээн зөвшөөрөгддөг бусад англи хэлний түвшин тогтоох шалгалт өгснийг гэрчлэх албан ёсны баримт бичгийн хуулбар, эх хувийн хамт эсвэл гадаад улсын их, дээд сургууль, коллежид бакалавр, магистр, докторын боловсролын зэргийн сургалтад англи хэлээр суралцаж төгссөн диплом, түүнтэй дүйцүүлэх албан ёсны баримт бичгийн хуулбар, эх хувийн хамт);

10/ Тухайн эмнэлгийг хөгжүүлэх төсөл (хагас бие даан хөгжүүлэх бодлого, бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц, санхүү, тусламж, үйлчилгээний төлөвлөлт, хүрэх үр дүн, үр ашигтай ажиллуулах зэрэг мэдээллийг тусгах);

11/ Улс төрийн намын гишүүн бус, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад удирдах албан тушаал эрхэлдэггүй, бусад байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагын бүрэлдэхүүнд хавсран ажилладаггүйг илэрхийлж бичсэн баталгаа;

12/ Хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагчийн талаарх лавлагаа;

13/ Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг;

Жич: Эх хувиар ирүүлсэн баримт бичгийг сонгон шалгаруулалт дууссаны дараа буцаан өгнө.

Гурав. Сонгон шалгаруулалт явуулах газар, хаяг

Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Төлөөлөн удирдах зөвлөл

Хаяг: Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 13 дугаар баг, О.Намнансүрэнгийн гудамж, Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төв

Дөрөв. Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах, бүртгэл явагдах хугацаа

Материалыг цаасан хэлбэрээр бүрдүүлж ирүүлнэ.

Бүрдүүлсэн материалыг болон материалын жагсаалт, тус бүрийн хуудасны тоог дурдаж, өөрийн гарын үсэг зурсан товъёогийг дугтуйнд хамт хийж битүүмжлэн, 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 18.00 цагаас өмнө дараах хаягаар хүлээлгэн өгч бүртгүүлнэ.

Хаяг: БОЭТ-ийн Хүүхдийн эмнэлгийн 3 давхарт

Утас: 88224838, 99214013

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ